

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гандяа	Дугаар	L314
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Арвайхээр
Төрсөн газар	Арвайхээр	Төрсөн он	1974
Ажил мэргэжил	Тус хийдийн гэсгүй лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Арвайн хүрээ	Сүм хийдийн дугаар	ӨХАХ 041
Одоогийн сүм хийд	Ганданпунцоглин хийд	Сүм хийдийн дугаар	ӨХАХ 040
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Арвайн хүрээ, Шинэ Ганданчойнхорлин хийд

Жужа: Энэ Ганданчойнхорлин хийд шинээр байгуулагдсан уу, аль эсвэл хуучин хүрээг сэргээсэн үү?

Гандяа: Хуучин хүрээг сэргээсэн. Сайн ноён хан аймгийн Агь үйзэнгийн хошууны Арвайн хүрээ. Номын бар ихтэй, хэвлэлийн төв хүрээ болж байсан юм.

Жужа: Тэр хүрээ хэдэн онд байгуулагдсан бэ?

Гандяа: Анхны цогчин дуган 1723 онд. Тэгээд тэрнээс хойш 16 дацантай, чойр, жуд, дүйнхор, ламиран, диваажин гээд 16 дацантай. 1000-аад ламтай байсан.

Жужа: Хүрээний гол сахиус шүтээн юу вэ?

Гандяа: Цам сахиустай.

Жужа: Цам бүжиг гардаг байсан үү?

Гандяа: Гардаг байсан . Хоёр цамтай, зун майдраар нэг цам хурдаг, өвөл сороор нэг цам хурдаг.

Жужа: Яг энэ хүрээний тэргүүн хамба ямар нэртэй хувилгаан байсан бэ?

Гандяа: Данжид лам гээд лам байсан. Тарган Данжид гээд. 5 удаа тодорсон, 5 дүртэй. Хамгийн сүүлчийнх нь гучин найманд онд 18-тай.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Ямар нэртэй лам байсан бэ?

Гандяа: Данзандаргиа гэдэг. 3 дахь дүр нь Цэвэлванчигдорж гээд 15 боть ном зохиолтой.

Жужа: Тэгээд тэр хурлын туурь нь яг хаана хаана байна бэ?

Гандяа: Одоо энүүгээр энэ хашаанд байна. Цогчин дуган нь энэ урд талд байсан.

Жужа: Хуучны зураг байхгүй юу?

Гандяа: Хуучны зураг байхгүй. Жижиг чулуун тууриуд нь л байна даа.

Жужа: Яг энэ хүрээнд шавилан сууж байсан өвгөн лам нар одоо байна уу?

Гандяа: Байна.

Жужа: Ямар ямар?

Гандяа: 5 лам байна. Зундуйдамбаа, эхэнд нь Самдан гэж лам байна. Одоо 98-тай лам манай багш байна.

Пунцагнамжил, Самдандамбаа, Түвчойндон ингээд 5 лам байна.

Жужа: Энэ хийдийг яг хэзээ нээсэн бэ?

Гандяа: 1990 оны 5 сард.

Жужа: Хэний санаачилгаар?

Гандяа: Анх хүрээнд сууж байсан 5 өвгөн ламын санаачилгаар. Одоо байгаа лам нар нь. Анх 40 гаран өвгөчүүл, лам нар байсан юм. Гол удирдаж байсан нь Цанжид гуай. Эд нар цуглаж ярьж байгаад л. Анхны хамба нь Түндүйдорж гэж хүн байсан.

Жужа: Тэр хуучин хүрээнээс ямар нэгэн шүтээн, судар үлдсэн юм байна уу?

Гандяа: Байгаа, тэр ном судар дандаа л айлуудын гэртээ байсан юмнууд.

Жужа: Шүтээн?

Гандяа: Судар л их үлдсэн, шүтээн ч байгаа. Одоо энэ 16 байгаа, хуучны.

Жужа: Барын хэвлэлийн газар байсан уу?

Гандяа: Байсан. Модон дуган, цогчингийн дуган тоосгон дуган байсан.

Жужа: Одоо энэ хийд хэдэн ламтай вэ?

Гандяа: 40-өөд лам одоо байна.

Жужа: Гэлэн сахилтай лам байгаа юу?

Гандяа: 8 байна. Хайлан уг нь бас хурсан юм. 2003 онд хурсан, энэ жил хурсан.

Жужа: Сарын дүйчэн өдөр хурдаг уу?

Гандяа: Шинийн найманд их манал, 15-нд сандуйн жүд, 20-нд цэндийн чог, 29-нд арван хангал, 30-нд найданг чог, шинийн 3-нд ганжуур, 10, 25-нд гүнрэг.

Жужа: Майдар эргэдэг үү?

Гандяа: Эргэнэ, намрын эхэн сарын шинийн найманд.

Жужа: Ганжуур хэзээ эргэх вэ?

Гандяа: Майдар эргэхээрээ хамт эргэнэ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Хайлан хурна?

Гандяа: Зуны адаг сард хайлан хурна.

Жужа: Ойролцоогоор хэдэн лам?

Гандяа: 20-иод лам хурна.

Жужа: Зоч лүйжинч лам нар байна үү?

Гандяа: 2 байна.

Жужа: Энд хэдэн дугнан байна вэ?

Гандяа: Нэг ламын өргөө, нэг гэр дуган, хоёр модон дуган байна.

Жужа: Цогчиныг хаана хурдаг вэ?

Гандяа: Том дугандаа. Хайлан хурна, сахиус хурна, нөгөө дугандаа.

Жужа: Гэр хэлбэртэй дуганд?

Гандяа: Хичээл заана.

Жужа: Энэтхэгийн шарын хийдүүдтэй холбоотой юу?

Гандяа: Холбоотой, сургуульд лам нар сурч байна. 10-аад лам байна.

Жужа: Хэдэн зэрэгт сурдаг вэ?

Гандяа: Янз янз, 2, 3, 5, 6, гээд л.

Жужа: Түвд лам нар ирдэг үү?

Гандяа: Байнга байхгүй, Ринбүүчийг ирэхээр л ирдэг.

Жужа: Ямар ямар цол хэргэм байна вэ?

Гандяа: Хамба гэж байна. Зундуйдамбаа. Ловон гэж байна. Тэгээд 2 гэсгүй байна. Даа лам гэж байна. Жижүүр, тогооч, дуганч лам.

Жужа: Хутагт хувилгаад их ирдэг үү?

Гандяа: Ирнэ.

Жужа: Бүтэн ганжуур байгаа юу?

Гандяа: Байна.

Жужа: Энэ дээр хуучин хүрээний яг аль дуган байсан бэ?

Гандяа: Энэ газар Данжид ламынх нь өргөө байсан юм. Барын дуган нь байсан юм. Энэ Чойрын дуганы хажуу талд.

Жужа: Яг энэ хийдийн бүдүүвч зураг байхгүй юу?

Гандяа: Байхгүй.

Энхбаяр. Зураад авчихая./ зургуулав бололтой /

Гандяа: Богдын хүрээ орох замд жоохон жоохон зам дагасан тийм өртөө хурлууд байдаг байсан.

Жужа: Тэгээд энэ хуучин чойр дацан гүнчин исчаатай байсан үү?

Гандяа: Гүнчин исчаа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Өндөр настай лам нараас одоо яг байгаа юу?

Гандяа: Байна.

Жужа: Түүнтэй ярилцаж болох уу?

Гандяа: Болно. Маанийн бүтээл долоо хоног болгон гурван хоног хурна.

Жужа: Хуучин хүрээнд ямар дэгтэй байсан бэ?

Гандяа: Ханчин дэгтэй л байсан.

Жужа: Одоо энэ аграмбын дамжаа байсан уу?

Гандяа: Аграмба байхгүй. Аграмба хүн энд гурав, дөрөвхөн байсан юм гэнэ лээ. Жамц гэж нэг аграмба байсан юм гэнэ лээ.

Жужа: Гавжийн дамжаа байсан уу?

Гандяа: Гавж байж. Чойрын хоёр дугантай, нэгэнд нь жилд хоёр гавжтай, нэгэнд нь жилд дөрвөн гавжтай.

Жужа: Зоч лам нар байсан уу?

Гандяа: Байсан, энэ талд нь горооноос гадна хол тусдаа дуган байсан.

Жужа: Хэдэн лам тэнд байсан бэ?

Гандяа: 10, 20 лам.

Жужа: Эмэгтэй лам, хандмаа байсан уу?

Гандяа: Үгүй.

Жужа: Лам нар аймагладаг байсан уу?

Гандяа: Үгүй, зүгээр л.

Жужа: Майдар эргэнэ?

Гандяа: Эргэнэ.

Жужа: Түвд лам нар байсан уу, хуучин?

Гандяа: Байсан.

Жужа: Ламын гэгээн өөрөө энд ирдэг байсан уу?

Гандяа: Ламын гэгээн ирдэггүй байсан юм. Тэр Гачин ламд их олон лам нар шавь ордог байсан юм. Вандан гавж.

Жужа: Ямар ямар ном барладаг байсан бэ?

Гандяа: Бүх л ном байсан. Энд тэндхийн ховор номнуудыг л их барладаг байсан.

Жужа: Хүрээг хэзээ хаасан бэ?

Гандяа: 1937 онд эхлээд 1938 онд бүр нураасан.

Жужа: 1937 он хүртэл майдар эргэдэг байсан уу?

Гандяа: Эргэдэг байсан. Хайлан хурдаг, гавжийн дамжаа барьдаг, дом тавьдаг байсан.

Жужа: Эргэн тойронд тахилгат газар байгаа юу, ямар ямар нэртэй?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гандяа: Байгаа. Ингээд энэ Наян хайрхан. Баруун хойно нь Өлзийт хайрхан.Гол бол олон байгаа. Сум болгонд л өөр өөрийн тахилгат овоо байгаа ш дээ.

Жужа: Өөр асуулт байхгүй ээ.